

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗРЫН 2015 ОНЫ АУДИТЫН ГЭРЧИЛГЭЭ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА БУЛГАН АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАР

ХҮНС ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗРЫН
ДАРГА Ч.АМГАЛАНД

63082 Булган аймаг, Булган сум, Жаргалант баг
Утас: 7034-2580, факс: 7034-2580

2016.02.25 № 63

Танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Булган аймгийн Хүнс, Хөдөө Аж Ахуйн газрын төсвийн 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон, аккруэл сууриар бэлтгэгдсэн, жилийн эцсийн санхүүгийн тайланд Төрийн аудитын тухай хуулийн 15.1.1-д заасан бүрэн эрхийн дагуу Үндэсний аудитын газраас аудит хийв.

Булган аймгийн Хүнс, Хөдөө Аж Ахуйн газрын удирдлага нь тайлант хугацааны санхүүгийн тайланг холбогдох хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу үнэн зөв бэлтгэж, тайлагнах үүрэг, хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллага нь Булган аймгийн Хүнс, Хөдөө Аж Ахуйн газрын 2015 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, санал дүгнэлт өгөх үүрэг, хариуцлага хүлээнэ.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журмын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журам нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Булган аймгийн Хүнс, Хөдөө Аж Ахуйн газрын 2015 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем, гол хууль тогтоомжуудын мөрдөлтийг болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгах аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан материаллаг алдаагүй эсэхэд санал дүгнэлт өгөх хангалттай бөгөөд зохистой үндэслэлийг бүрдүүлсэн.

